

ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ



“Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэд зориулсан гарын авлага”

Агуулга

| | |
|---|----|
| 1. Зорилго | 3 |
| 2. Хамрах хүрээ | 3 |
| 3. Нэр томъёоны тодорхойлолт | 3 |
| 4. Олборлолтын улмаас эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийн төлөвлөлтөд тавигдах ерөнхий шаардлага | 3 |
| 5. Нөхөн сэргээлтийн ажилд тавигдах шаардлага | 5 |
| 5.1. Нөхөн сэргээлт хийх арга техник | 6 |
| 5.2. Техникийн нөхөн сэргээлт | 7 |
| 5.3. Техникийн нөхөн сэргээлтийн гүйцэтгэл | 8 |
| 5.4. Биологийн нөхөн сэргээлт | 9 |
| 6. Хяналт мониторинг | 10 |

1. Зорилго

Энэхүү гарын авлага нь түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч нарт нөхөн сэргээлтийн ажлыг зөв зохистой төлөвлөх, гүйцэтгэхэд гарын авлага болох хэрэгтэй мэдээллийг өгөх зорилготой.

2. Хамрах хүрээ

Тухайн гарын авлага нь Улаанбаатар хотын хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмал эрж хайх, ашиглах үйл ажиллагаа эрхэлж буй иргэн аж ахуйн нэгжид хамаарна.

3. Нэр томъёоны тодорхойлолт

Түгээмэл тархацтай ашигт малтмал - гэж зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой элбэг тархалт бүхий элс, хайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайргын зориулалттай барилгын чулууны хуримтлалыг хэлнэ;

Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх - гэж түгээмэл тархацтай ашигт малтмалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг хэлнэ;

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах - гэж түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу газрын гадаргуу хэвлийгээс ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг хэлнэ;

Нөхөн сэргээлт - гэж эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг сэргээх, хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээг хэлнэ;

Техникийн нөхөн сэргээлт - гэж уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт дүүргэлт хийх, хэлбэршүүлэх, тэгшлэх, шимт хөрсөөр хучих зэргээр биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэх ажлын үе шатыг хэлнэ;

Ил аргаар ашиглах - гэж хөрс хуулалт олборлолтын ажил нь газрын гадаргууд ил орон зайд явагддаг, ашигт малтмалын ордыг ашиглах аргыг хэлнэ¹.

4. Олборлолтын улмаас эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийн төлөвлөлтөд тавигдах ерөнхий шаардлага

Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газар нь ихээхэн эзлэхүүн бүхий ухаш үүсгэдэг ба ухашийг харьцангуй бага хэмжээний дүүргэлт ашиглан дүүргэж, ухашийн өнцөг хэвгийг хэлбэржүүлэн нөхөн сэргээлт хийдгээрээ бусад ашигт малтмалын орд газруудын нөхөн сэргээлтээс ялгагддаг. Тухайн ашигт малтмалыг олборлох үйл ажиллагаанаас эвдэрсэн талбайд дараах чиглэлээр нөхөн сэргээлтийг хийж болно. Үүнд:


¹ MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт

- Хөдөө аж ахуй,
- Жимс, жимсгэнэ, мод бут тариалалт,
- Усан сан, засагны аж ахуй,
- Амралт сувилал,
- Ойжуулах,
- Үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламж.

Нөхөн сэргээлтийн ажлын өөр нэг зорилт нь бохирдлын удирдлага, түүнчлэн хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд учруулж болзошгүй эрсдэлийн удирдлагыг хангахад оршино.

Эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийх газрын хил хязгаарыг дараах байдлаар тогтооно.Үүнд:

- Нөхөн сэргээлт хийх талбайн солбицлыг GPS-ээр хэмжиж, том масштабын зурагт буулган эвдэрсэн талбайн хэмжээг тодорхойлох;
- GPS-ээр хэмжиж тогтоосон координатын цэгүүд дээр чулуу бөөгнүүлж тавих, жижиг дарцаг хатгах, тэмдэглэгээ бүхий пайз тавих зэргээр тэмдэгжүүлэх;
- Талбайн зах орчмын замууд болон өндөрлөг цэгүүд дээр “Нөхөн сэргээлт хийгдэж байна, нөхөн сэргээлтээс өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн бичээс бүхий жижиг самбар байрлуулах;
- Талбайн хилийг тэмдэгжүүлэхдээ газар ухаж зурвас гаргах, шуудуу татах зэргээр ямар нэгэн байдлаар орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байх.



Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд газар нь ихээхэн эзлэхүүн бүхий ухаш үүсгэдэг ба ухашийг харьцангуй бага хэмжээний дүүргэлт ашиглан дүүргэж, ухашийн өнцөг хэвгийг хэлбэржүүлэн нөхөн сэргээлт хийдгээрээ бусад ашигт малтмалын орд газруудын нөхөн сэргээлтээс ялгагддаг.

Олборлолтын улмас эвдэрсэн газрыг цаашид ашиглах чиглэлийг харгалзан нөхөн сэргээлтийн ойрын болон дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулна. Төлөвлөгөөг боловсруулахдаа дараах агуулгыг заавал тусгасан байвал зохино. Үүнд:

- Дулааны улирлын олборлолтын хэмжээ багасах, хөрс хуулалт түлхүү хийгдэх үед нь технологийн үндсэн тоног төхөөрөмжийг техникийн нөхөн сэргээлтийн ажилд зохистойгоор хуваарилах,
- Зарим ховор болон ховордсон мод, ургамлыг шилжүүлэн суулгах, ургамалжуулсан талбайг тусгайлан хамгаалах арга хэмжээг тусгах,
- нөхөн сэргээлтийн ажлын технологийн бүдүүвчийг урьдчилан гаргах,
- төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу нөхөн сэргээлт хийгдэх газрын эргэн тойрныг мал, амьтан орохоос сэргийлэн хашаалж, тэмдэгжүүлэх,
- Нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах зардлыг тооцож, түүний эх үүсвэрийг урьдчилан тодорхойлох.

Мөн нөхөн сэргээлтэд ашиглах гар багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж (хүрз, лоом, жоотуу, цахилгаан өрөм, шаардлагатай тохиолдолд уул уурхайн бага оврын машин техник г.м)-ийг бэлтгэж, малталтаас гарах хөрс, уулын чулуулгийг хэрхэн байршуулах (дотоод, гадаад овоолго, шимт хөрсний овоолго, нөхөн дүүргэлт хийх г.м) тооцоо судалгаа хийж, техникийн нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах хэрэгтэй.

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт барилга байгууламж барьж байгуулах чиглэлээр нөхөн сэргээлт хийхэд ихэвчлэн хүн ам төвлөрөн суурьшсан газрыг хамруулах шаардлагатай.



Зураг 1. Нөхөн сэргээлт хийгдсэн байдал

Уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрыг нөхөн сэргээснээр хүнсний ногооны агуулах, бараа материал, техник тоног төхөөрөмжийн агуулах, гарааш, авто засварын газар, төмөр бетон эдлэлийн үйлдвэр, хүлэмжийн аж ахуй гэх мэт барилга байгууламж байгуулах боломжтой.


5. Нөхөн сэргээлтийн ажилд тавигдах шаардлага

Байгаль хамгааллын чиглэлээр нөхөн сэргээлт хийхэд тухайн эвдэрсэн газраас хүрээлэн буй орчны газар нутаг, гадаргын болон газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах байдлаар нөхөн сэргээх үйл ажиллагаанд дараахыг багтаасан байна. Үүнд:

- Эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх арга ажиллагааг тухайн газрын хөрсийг бүрдүүлэгч чулуулгийн байдал, бүрэлдэхүүн ба шинж чанар, байгаль-цаг уурын нөхцөл, техник-эдийн засгийн үзүүлэлтээс нь хамааруулан сонгох;

- Эвдэрсэн газрын гадаргыг бэхжүүлэхэд хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байхаас гадна усны үйлчлэл, температурын хэлбэлзлийг даах чадвартай наалдамтгай материалыг хэрэглэх;
- Хөрс сайжруулах арга ажиллагааг бүрэн хэрэгжүүлэх;
- Лагийн талбай, хаягдлын сан болон хорт бодис агуулсан үйлдвэрийн овоолгуудад зохих норм, шаардлагын дагуу хоргүйжүүлэлт, саармагжуулалт хийх;
- Агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд тоос, хорт хийн ялгаралтыг зөвшөөрөгдөх дээд хэмжээнд хүртэл бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Эвдэрсэн газрыг үйлдвэрийн, иргэний болон бусад барилга байгууламж барих зориулалтаар ашиглахад тохиромжтой эсэхийг тухайн газрын төлөвлөлт, барилгажуулалтын ерөнхий төлөвлөгөө, инженер-геологийн судалгааны өгөгдлүүд болон холбогдох техник-эдийн засгийн тооцооны үр дүнд үндэслэн тогтоох шаардлагатай.



Зураг 2. Талбайд налуу үүсгэх загвар

Барилга байгууламжийн чиглэлээр нөхөн сэргээх эвдэрсэн газрын инженер-геологийн судалгааг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Барилгын норм дүрэм”-ийн шаардлагын дагуу явуулна.

Ил уурхайн нөхөн сэргээсэн газарт барьж байгуулах барилга байгууламжийн хийц загвар нь хамгийн ойр зэргэлдээ орших суурин газрын барилга архитектурын шийдэлтэй ижил буюу түүнтэй ойролцоо байвал зохимжтой.

5.1. Нөхөн сэргээлт хийх арга техник

Нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөн гүйцэтгэхдээ тухайн талбайн онцлог төрх, ашигт малтмалын олборлолтын үе шатыг харгалзан үзэж дараах аргаар хийнэ. Үүнд:

- Техникийн;
- Биологийн.

Нөхөн сэргээх газрын байршлуудыг тодорхойлох:

Нөхөн сэргээх газрын байршлыг тухайн ландшафт, ирээдүйд ашиглаж болох нөөцөд саад болохгүй, гадаргуугийн усны урсцын чиглэлийг бодолцож нөхөн сэргээх газрыг байршуулах нь тэнд буй голын урсгалыг өөрчлөхгүй, эсхүл урсацад саад болохгүй байх нөхцлийг хангана. Мөн ан амьтны уст цэгт хүрэх хөдөлгөөнд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байхыг анхаарах хэрэгтэй.

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙГ ХИЙХ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БА ХЭРЭГЖИЛТ

| | |
|-----------|---|
| 01 | Нөхөн сэргээлтийн зорилго |
| 02 | Нөхөн сэргээлтийн төлөвлөлт |
| 03 | Нөхөн сэргээлтийг хийж дуусгах шалгуур |
| 04 | Нөхөн сэргээлтийн удирдлага ба мониторинг |

НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТЕХНОЛОГИУД




Ландшафтын зураг төсөл ба бүтээн байгуулалт

Хөрсний хэв шинж бүтцийг сэргээх



Тохиромжтой төрөл зүйлийг сонгох

Ургамлын төрөл зүйлийг тогтоох



Амьтны төрөл зүйлийг эргүүлж нутагшуулах

5.2. Техникийн нөхөн сэргээлт

Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг эхлэхийн өмнө доорх бэлтгэл ажлыг сайтар хангана. Үүнд:

- Өнгөн хөрсний алдагдал болон бусад хүчин зүйлүүдэд үнэлгээ хийсний үндсэн дээр газрын эвдрэлийн хэмжээг багаас дунд, дундаас их хэмээн тодорхойлон ангилах;
- Тухайн газрын одоогийн болон цаашдын газар ашиглалтын хэлбэрийг үнэлэх: бэлчээр, хөдөө аж ахуйн газар, байгаль хамгаалах газар, эрэг орчмын хөндий, сайр (голын хөндий) гм.
- Нөхөн сэргээлт хийгдсэн газарт борооны ус тогтонги ус үүсгэлгүйгээр урсаж байхаар төлөвлөх;
- Элс олборлолт хийсэн газарт шимт хөрсөөр хучилт хийх боломжгүй тул 5-12 мм -ийн диаметртэй хайрга, дайргаар нимгэн хучилт хийж элсний нүүдэл хөдөлгөөнийг барина.²
- Нөхөн сэргээлтийн ажлыг эхлэхийн өмнө нөхөн сэргээлт хийх талбай болон орчны эвдрэлд ороогүй хөрснөөс дээж авч, шинжилгээ хийлгэх; хөрсний шинжилгээ нь хөрсөн дэх органик агууламж, механик бүрэлдэхүүн, рН, карбонатын агууламж зэргийг шинжилнэ. Байгаль орчны хяналтын байцаагчийн шийдвэрээр шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хөрсний бохирдлыг шинжлэх иж бүрэн шинжилгээ хийлгэх шаардлагатай.
- Уурхайн үйл ажиллагаанд өртсөн хуурай сайр, гол, горхины голдирлыг анхны байршлаар нь нөхөн сэргээх ба нөхөн сэргээсэн голдирлын эргийн налуу 25⁰-аас ихгүй байна. /MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага/
- Газрын гүний устай талбайд түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож бий болгосон ил уурхайн бүх ханыг 18⁰-аас ихгүйгээр налуулалт хийн тэгшилж усны түвшнээс дээших хэсгийг ургамалжуулна.

5.2.1. Техникийн нөхөн сэргээлтийн гүйцэтгэл

Газрын гадаргууд ойр өнгөн хэсэгт илүү жижиг, хөнгөн материал буюу хайрга, элс ашиглавал тохиромжтой. Талбайд үүссэн овон товон гадаргууг тэгшлэн тухайн талбайн гадаргуугийн хэлбэр төрхтэй ойртуулан хэлбэршүүлэх, тогтворжуулах арга хэмжээ авна.

Усны урсгалын нөлөөгөөр элэгдэлд өртөж болзошгүй жалганд усны элэгдлээс сэргийлэх, хөрсний тогтвортой байдлыг хангах зорилгоор олборлолтоос үүссэн овоолго материал, чулуулгаар дүүргэлт хийнэ.

Нөхөн сэргээлтийн бэлтгэл үед хийгдсэн гидрологийн үнэлгээний дагуу усны голдирол бүхий газруудад урсгалын нөлөөнд өртөж эвдрэхээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордын хувьд уурхайн бага оврын техник ашиглан, овоолго, хаягдал чулуулаг, хана мөргөцгийн оройг намсгаж, хэлбэршүүлэх, машин техник ашигласны улмаас дагтаршиж, нягтарсан хөрсийг сийрэгжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

² Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2022 оны 8 дугаар сарын 29-ны өдрийн А/328 дугаар тушаалын хавсралт

Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрын гадаргууг эхлээд хөрсөн доорх шимтлэг шороогоор дараа нь хадгалсан шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлт хийхэд тохиромжтой байх нөхцөлөөр хангахыг зорино.

5.3. Биологийн нөхөн сэргээлт

Нөхөн сэргээлтийн ажлын зорилт, үр дүн, сэргээлтийн дараа газрыг ямар зориулалтаар ашиглах зэрэг хүчин зүйлс нь нөхөн сэргээлт хийх газарт ашиглах ургамлын төрлийг сонгоход чухал нөлөөтэй.

Нөхөн сэргээлтийн ажлыг хийхэд “Байгаль орчин. Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2023 стандартыг баримтлана. Мөн ургамлын сонголтыг хийхдээ UCS 0802C:2022 Мод, таримал ургамлын төрөл зүйлийн лавлах гэсэн стандартыг ашиглавал зохино.

Хүснэгт 1. Хучилт хийх хөрсийг эрдсийн хольцоор ангилсан ангилал³

| Чулуулгийн зэрэглэл | Тохирох төлөв | Хөрсний эрдэс, чулуулаг |
|---------------------|--|--|
| I | Бүрэн тохирох | Эрдсийн хольц: гялтгануур, мантмориллонит, хлорит, вермикулит, карбонатууд 25%, хээрийн жонш, цахиур, алтан химэрлэг маягийн элсэнцэр, ялзмаг нь 2%-оос их |
| II | Тохирох | Эрдсийн хольцоор I зэрэглэлтэй адил төстэй боловч, ялзмаг нь 2%-иас хэтрэхгүй |
| III | Сайжруулах арга хэмжээ авах шаардлагатай | Холбогч бүхий цахиурын элс, глукунитын элсэнцэр, шаварлаг бахгалит, галтмар бүхий хөрс, ялзмаг нь 1.5%-иас бага |
| IV | Үндсээр нь сайжруулах шаардлагатай | Цахиурын элс, хүнд шавар, чулуулаг хөрс, палыгорскит, мантомориллонит, цэрд, бадмар, каолин, гөлтгөнө, галтмар зэргийн аль нэг нь давамгайлсан (75%-иас дээш) ялзмаг нь 1%-иас баг |

Хөрсний физик, хими, биологийн онцлогийг анхаарч үзэж ургамалжуулах шаардлагатай.

Эхлэлийн төсөл, төлөвлөгөө нилээд ихээр шинэчлэгдсэн бол уурхайн хаалтын дараах ландшафт, талбайн газар хөрсөнд тохирсон орон нутгийн байгалийн ижил төстэй талбайг олж эко тогтолцоонд ашиглах загвар болгоно.

Хэрэв байгалийн унаган төрхийн жишээ олдохгүй бол тухайн нөхцөл байдалд тэсвэртэй, олон төрөл, зүйлтэй зохицох ургамлын төрөл зүйлийг олж нөхөн сэргээлтэд ашиглах ба харь зүйлийн болон ганц, хоёр наст ургамлын зүйлийг нөхөн сэргээлтэд хэрэглэхгүй.

Үрийн хольцийг хэдэн хувиар тооцож тарилт хийхийг MNS5918:2023 стандарт заасны дагуу гүйцээгэвэл зохино.

³ Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2022 оны 8 дугаар сарын 29-ны өдрийн А/328 дугаар тушаалын хавсралт, хуудас 5.

Хүснэгт 2. Ил уурхайн ашиглалтын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх чиглэл⁴

| Нөхөн сэргээх чиглэл | | Нөхөн сэргээсэн газрыг ашиглах хэлбэр |
|-----------------------|-----------------------|--|
| Хөдөө аж ахуйн чиглэл | | Бэлчээр, хадлан, тариалангийн талбай болгох |
| Ойн аж ахуйн | | Аж ахуйн зориулалтаар болон хамгаалалтын зурвас үүсгэн ойжуулалт хийх, мод үржүүлгийн газар, үрсэлгээний талбай байгуулах |
| Усны аж ахуйн | | Ахуй, үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, тариалангийн талбайн усжуулалт, усан спортын болон эрүүлжүүлэх зориулалттай усан сан, загасны аж ахуйн зориулалттай усан сан байгуулах |
| Тусгай зориулалт | Амралт сувилал, спорт | Соёл, амралтын хүрээлэн, аялал жуулчлалын бааз, амралт, сувиллын барилга байгууламж, биеийн тамир спортын цогцолбор барьж байгуулах |
| | Байгаль хамгаалал | Ойжуулах, ургамалжуулах, ногоон байгууламж байгуулах |
| | Барилга байгууламж | Үйлдвэрлэлийн, иргэний болон бусад төрлийн барилга байгууламж болон уулын чулуулаг, барилгын хог хаягдал, баяжуулалтаас үүссэн хаягдал хадгалах байгууламжийг барьж байгуулах |

Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт явуулсан ил уурхайн бүх хажуу ханыг 18⁰-аас ихгүйгээр налуулж тэгшлэн ургамалжуулна.

6. Хяналт мониторинг

Газрын хэвлийн баялгийг хайх, олборлох, баяжуулах болон түүний дэд бүтцийн төслийн үйл ажиллагаа явагдсанаар тухайн газар нутаг, бүсийн хэмжээнд үзүүлэх байгаль орчны нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тухайн жилийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.



Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн зардлаар жил бүр нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөж, тухайн жилийн байгаль орчны менежментийг төлөвлөгөө (БОМТ)-г шинэчлэн боловсруулан хэрэгжүүлнэ. (МУ хууль, БОНБҮ-ний тухай, 2012)

Хяналт мониторингийн хүрээнд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг дараах чиглэлээр тогтмол хийлгэнэ. Үүнд:

- ✓ Агаар орчин,
- ✓ Усан орчин,
- ✓ Хөрс,

⁴ БОНХАЖ-ын сайдын 2015 оны А-138 дугаар тушаалын хавсралт

- ✓ Амьтан, ургамал.



Зураг 3. Хяналтыг хэрэгжүүлэх үйл явцын дараалал

Усан орчны хяналтыг хэрэгжүүлэхдээ “Усны чанар. Дээж авах: 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах MNS ISO 5667-11:2000”-г дагаж мөрдөнө.

Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (БОАЖЯ) баталж, биелэлтийг хянана. Биелэлтийг төсөл хэрэгжүүлэгчийн төлөөллийг байлцуулан нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэд, нутгийн захиргааны байгууллагын хамтарсан аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг газар дээр нь шалгаж дүгнэх бөгөөд биелэлтийн дундаж хувь хангалттай тохиолдолд дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах үндэслэл болдог⁵.

Ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгон тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлынхаа 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр тайлагнана.

⁵ БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 тоот тушаалын хавсралт